

Сэтгүүлчийн ёс зүйн тулгамдсан асуудлууд

Ч. Чойсамба*

* МУИС, НУФ, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, дэд доктор, дэд профессор

Энэ өгүүллийг ARC-ийн дэмжлэгээр хийсэн "Чөлөөт хэвлэлийн төлөвшил, олон нийтийн санаа бодол" судалгааны хүрээнд бичсэн болно

Одоогоос зуу орчим жилийн тэртээ дэлхийн тэргүүний орнуудад боловсролтой хүмүүсийн тоо нэмэгдэж, тэдний ухамсар дээшлэхийн хирээр олон түмнийг сэтгүүлчид эрээ цээргүй, хүссэнээрээ мунхруулж байгаад зүй ёсоор бухимдаж эхэлсэн байна.

Олон түмэнд буюу массд хандсан хэвлэл 1830-аад оны үед АНУ-ад үүсэхдээ анхнаасаа л шуугиан сенсаци, гэмт хэргийн тухай энгийн хэллэгээр бичигдсэн нийтлэлүүдийг амтархан уншдаг бүдүүлэгдүү аудиторийг бай болгожээ. Ийм хэвлэлийн «загалмайлан эцэг» нь Бенжамин Дэй юм. 1833 оны 9 дүгээр сарын 3-нд Нью-Йоркт «Нар бүгдийг гэрэлтүүлдэг» уриатай «The Sun» («Нар») сонины анхны дугаар уншигчдын гар дээр очсон байна. Шуугиан сенсаци, гэмт хэрэгт түлхүү анхаардаг Дэй сонирхолтой материал олдохгүй болохоор санаанаасаа зохиочих нь энгийн үзэгдэл болов. «The Sun»-ы 1835 оны 8 дугаар сарын 25-ны дугаарт нийтлэгдсэн одон орон судлаач Жон

Гершель Өмнөд Африкийн Таатай найдварын хошуун дээр байрлуулсан асар хүчтэй телескопын тусламжтайгаар Саран дээр амьдардаг жижигхэн хүмүүсийг илрүүлсэн тухай мэдээлэл олныг шуугиулжээ. Энэхүү мэдээллийг Английн «The Edinburgh Journal»-ын хавсралтаас авснаа сонин дурдсан байна. Дараагийн дугаарт Саран дээр амьдардаг хүмүүсийг: «Өндөрөөрөө 122 см орчим, нүүрнээсээ бусад биеийн хэсгээр шаравтар үсэн бүрхүүлтэй, багваахай шиг сарьсан далавчтай» гэж дүрсэлжээ. «The Sun»-ы борлогдох хувь хэдхэн өдрийн дотор хэд дахин нэмэгдэв. Уншигчид редакцийн газрыг захидлаар булж, саранчуудын ахуй амьдралын тухай үргэлжлүүлэн нийтлэх, болж өгвөл тэднийг дүрсэлсэн зураг гаргахыг нэгэн дуугаар шаардаж байлаа. «Тэднийг дуран авайгаар харж байхад хоорондоо юм ярьж байсан нь илэрхий» гэх зэрэг мэдээлэл гэнэн уншигчдыг итгүүлж чаджээ. Удалгүй Англиас «The Edinburgh Journal»-д ямар ч хавсралт байхгүй, «The Sun»-ы нийтлэл бодит үнэнд нийцэхгүй болохыг хариуцлагатайгаар мэдэгдсэнээр Сарны үлгэр

дуусгавар болжээ. Гэвч тус сонин нэгэнт өөрийн хүрээний уншигчидтай болсон аж¹.

«The Sun»-ы араас нийтлэлийн бодлогын хувьд анхдагчаа өвчсөн мэт дууриасан хэвлэлүүд шил шилээ даган үүсчээ. XIX зууны 2-р хагас бол олон түмний хэвлэлийн цэцэглэлтийн үе байлаа. Ийм хэвлэл Англи, Франц зэрэг оронд үүсч, асар богино хугацаанд олон түмний итгэлийг «байлдан дагуулж» байв.

Гэвч дээр дурдсанчлан XX зууны эхээр дураараа дургиж, хүссэн бүхнээ бичиж байдаг сэтгүүлчдэд даруулга хэрэгтэй гэсэн шаардлага улам бүр тод сонсогдох болов. Сэтгүүлчид ч өөрсдөө өөрсдийгөө дотроосоо цэвэрлэж, муу цусаа ханах цаг

нэгэнт болсныг хүлээн зөвшөөрчээ. Ингэснээр Шведэд 1900 оны орчим сэтгүүлчдэд зориулсан ёс зүйн зарчмыг баталсан байна. Харамсалтай нь энэхүү зарчим олны хүртээл болж чадаагүй аж. Тиймээс Францад Сэтгүүлчдийн үндэсний синдикатаар 1918 онд баталсан «Зан явдлын харти»-г сэтгүүлчдийн ёс зүйн анхны зарчим гэж үздэг. Энэ үеэс эхлэн олон улсын сэтгүүлчдийн уулзалт-хурлууд зохиогдох болжээ. 1921 онд Гонолулуд болсон эдгээр уулзалт-хурлын нэгнийх нь үеэр Америкийн сэтгүүлч Жеймс Браун сэтгүүлчдэд зориулсан зан явдлын олон улсын зарчим батлахыг санал болгосон

юм. Гэвч хурлаар түүний зохиосон «Сэтгүүлчийн практикийн ёс зүй хийгээд хэм хэмжээний кодекс»-ыг батлаагүй байна.

Хэдийгээр Брауны санал дэмжлэг аваагүй ч уулзалт-хурлын нөлөөн дор Швед, Бразил, Финлянд зэрэг улсад сэтгүүлчид өөр өөрсдийн ёс зүйн зарчмыг боловсруулж, баталж, мөрдөж эхэлсэн нь том амжилт байлаа. 1923 онд «Сэтгүүл зүйн канонууд» нэртэй ёс зүйн зарчмыг

АНУ-ад баталсан байна. Энэхүү зарчмыг баталсан Америкийн сонин редакторуудын нийгэмлэг өдгөө ч үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд сэтгүүлчийн ёс зүйн асуудлуудыг тусгадаг товхимлыг сар тутам хэвлэдэг ажээ².

Сэтгүүлчийн ёс зүйн анхны зарчмуудыг үзэхэд тэдгээрийг зохиогчид нь чөлөөт хэвлэлийн буюу либерталь концепцийг баримтлагчид байсан нь илэрхий. Тус концепци XVII-XVIII зууны сэтгэгчид Жон Мильтон, Томас Жефферсон, Жон Стюарт Миллийн үзэл бодлоос гол санаагаа шавхсан байдаг. Либерталь концепцийн үндсэн санааг базвал:

1. Хэвлэл бол нийгмийн институт мөн бөгөөд мэдээлэх, олон түмнийг зугаацуулах, төр засгийг хянахад ард түмэнд тусалдаг гол хэрэгсэл юм. Товчоор хэлвэл, хэвлэл бол ардчиллын хоточ нохой мөн.

«

Гэвч дээр дурдсанчлан XX зууны эхээр дураараа дургиж, хүссэн бүхнээ бичиж байдаг сэтгүүлчдэд даруулга хэрэгтэй гэсэн шаардлага улам бүр тод сонсогдох болов. Сэтгүүлчид ч өөрсдөө өөрсдийгөө дотроосоо цэвэрлэж, муу цусаа ханах цаг нэгэнт болсныг хүлээн зөвшөөрчээ.

»

2. Хэвлэл бол иргэн бүрт нээлттэй бөгөөд бололцоотой хүн бүхэн сонин гаргах эрхтэй.

3. Гүжир гүтгэлэг, ёс зүйгүй авир хэвлэлд харш.

4. Хэвлэл бол дөрөв дэх засаглал. Хэвлэл нийгмийн өмнө хариуцлага хүлээнэ.

Эдгээр санаан дээр тулгуурлан зохиогдсон ёс зүйн анхны зарчмуудад хэвлэлийн эрх чөлөө, үнэн бодит мэдээлэл авах ард түмний эрхийг тунхагласан байдаг. Сэтгүүлчийн ёс зүйн анхны зарчмуудын гол санааг тоймловол: үнэнийг бич, баримтад тулгуурла, хүний нэр төр, хувийн амьдралыг хүндэтгэ, авилга бүү ав, гаргасан алдаагаа залруулж бай, мэдээллийг цуглуулах, түгээхдээ шудрага бай, ардчилсан ёсыг хүндэтгэ, хүний ёс суртахууны түгээмэл хэм хэмжээг бүү зөрч гэсэн шаардлага тавьж байв. Ёс зүйн анхны зарчмуудын гол дутагдал бол сэтгүүлчийн мэргэжлийн онцлогийг сайн тусгаж чадаагүй байсан явдал юм.

Либерталь онол дээр тулгуурлан ХХ зуунд «нийгмийн өмнө хэвлэлийн хүлээх хариуцлагын онол» бий болжээ. Энэхүү онолын гавьяа нь нэг талаас хэвлэлийн эрх чөлөө, нөгөө талаас түүнийг хэтрүүлэн ашиглахын хооронд тодорхой зааг тогтоосон явдал юм. Нийгмийн өмнө хэвлэлийн хүлээх хариуцлагын онолыг орчин үеийнх нь хэлбэрээр ХХ зууны 40-өөд оны сүүлээр АНУ-ын судлаач У.Э.Хокинг боловсруулжээ. Өдгөө түүний боловсруулсан онолын суурь санаануудыг дэлхийн олон орны сэтгүүлчдийн байгууллага ёс зүйн зарчимдаа тусгасан байдаг.

Европын улс орнуудад үйлчилдэг сэтгүүлчийн ёс зүйн зарчмын 30 тунхагийг Финляндын судлаач Тийна Лайтилагийн судалсан байдал сонирхолтой. Энэхүү 30 тунхагт түгээмэл 21 зарчим байгааг тэрээр онцолсон байдаг. Эдгээр түгээмэл зарчмыг тус бүрд нь үзье.

Мэдээллийн үнэн бодит байдлыг эрхэмлэх (1), мөн гаргасан алдаагаа залруулах (2), ямар ч хэлбэрээр авилга авах (3), арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхахыг (4) судалгаанд хамрагдсан тунхгуудын 25 нь (89 хувь) онцгойлон заажээ.

Мэдээллийг шудрага аргаар цуглуулна (5), мөн хүний хувийн амьдралыг хүндэтгэнэ (6) гэсэн заалт 24 тунхагт (86 хувь) орсон байна.

Нийгмийн болон ангийн шинж, бэлгийн сонирхлоор нь хүнийг гадуурхахгүй байхыг (7) 23 тунхаг (82 хувь) сэтгүүлчдээс шаарджээ. 1970-1980-аад онд батлагдсан сэтгүүлчийн ёс зүйн зарчмуудад ийм заалт байгаагүйг дурдах хэрэгтэй юм. Мөн 23 тунхагт сэтгүүлч мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахдаа гадны ямар нэг нөлөөнд автахгүй байхыг (8) тэмдэглэсэн байна.

Мэргэжлийн нууцаа хадгалах (9), мэргэжлээ хувьдаа ашиг олох хэрэгсэл болгож ашиглахыг (10) хориглосон, түүнчлэн үзэл бодлоо илэрхийлэх, шүүмжлэх, тайлбар хийх эрх чөлөөг олон түмэнд олгохыг шаардсан (11) заалт 21 тунхагт (75 хувь) оржээ.

Гэмт хэрэг, золгүй тохиолдлын тухай мэдээлэхдээ ямар байр суурьтай бай-

хыг (12) 19 тунхагт (68 хувь) тусгасан байна.

Судалгаанд хамрагдсан тунхагуудын 17-д нь үзэл бодол хийгээд баримтыг зааглах (13), далд реклам ба мэдээллийг зааглах (14), зохиогчийн эрхийг хүндэтгэх (15), баримт ба мэдээллийн эх сурвалжаа шалгаж байх (16), хяналттай тэмцэж байхыг (17) шаардсан заалт орсон байна.

Цаашлаад хов яриаг үндэслэж мэдээлэл түгээх (18), хэн нэгнийг үндэслэлгүй буруутгах (19), мэдээллийг нуун дарагдуулах (20), сэтгүүлч өөрийгөө худал танилцуулахыг (21) 16 тунхаг буруушаажээ³.

Манай улсаас өөр сэтгүүлчийн ёс зүйн зарчимгүй орон дэлхий дээр олон биш байдаг болов уу. Нийгэмд ОНМХ-ийн гүйцэтгэх үүрэг нэмэгдэхийн хирээр сэтгүүлчийн ёс зүйн зарчмын ач холбогдол улам бүр өсч байна. Чухамдаа сэтгүүлч жирийн иргэнээс авахуулаад удирдах албан тушаалтан, сайд дарга, төрийн тэргүүнийг хүртэл ОНМХ-ээр шүүмжлэх эрхээр хангагдсан байдаг. Гагцхүү сэтгүүлчийг л ОНМХ-ээр шүүмжлэх тийм дархан эрх хэнд ч заяагдаагүй. Байдал ийм учир алдсан эндсэн нэгнийхээ алдаа дутагдлыг нь засч залруулахад туслах, нэгэнт гаргасан алдаагаа хойшид давтахгүй байх, өөр мэргэжлийнхэнд байдаггүй давуу эрхээ хэтрүүлэн ашиглаж, хэн нэгэнд

сэтгэл санааны болон бусад хохирол учруулахгүйн тулд сэтгүүлч сэтгүүлчээ шүүмжилж байхаас өөр арга үгүй юм. Эмч ганцхан өвчтөнийг л эмчилнэ. Тэгвэл нийгмийг бүхэлд нь эмчилж байдаг, бас цагдаж байдаг нийгмийн эмч, нийгмийн

цагдаагийн үүргийг давхар гүйцэтгэдэг сэтгүүлч өөрөө хэдий чинээ ёс зүйтэй байна, төдий чинээ түүний үг жин татна.

Өнөөгийн манай сэтгүүлчдийн өмнө хамгийн ихээр тулгамдсан асуудал

«
Судалгаанд хамрагдагсдын дөнгөж 10.1 хувь нь манай сэтгүүлчдийн ёс зүйн баримтлал, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлага сайн төвшинд байна гэж үзсэн бол 8.6 хувь нь энэ асуултанд хариулж мэдэхгүй байна гэжээ. Харин үлдсэн 81.3 хувь нь сэтгүүлчдийн эсрэг саналаа өгсөн байна.

»

бол яах аргагүй энэхүү мэргэжлийн ёс зүй, нийгмийн өмнө сэтгүүлчдийн хүлээсэн хариуцлага юм. Сэтгүүлчдийн мэргэжлийн ёс зүйн төвшин эрс доошилсон, сэтгүүлчийн нэр хүнд хүн алж, хүрээ тэлсэн алуучныхаас нэг их дээрдэхээргүй болсон, сэтгүүлч бол цорын ганц зэвсэг – үзгээ, цорын ганц өмч – оюунаа худалддаг «биеэ үнэлэгч» болж хувирсан тухай сүүлийн үед нэг бус удаа яригдаж, мэргэжлийн судлаачид төдийгүй, жирийн уншигчид ч үүнийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй болжээ.

Мэргэжил болгон, тухайлбал: шүүгч, өмгөөлөгч, байцаагч, багш г. м. өөр өөрийн ёс зүйтэй байдаг. Нийгмийн «эмч», нийгмийн «цагдаа»-гийн үүргийг гүйцэтгэдэг сэтгүүлч ч гэсэн мөн өөрийн ёс зүйтэй. Энэхүү ёс зүй нь нийгмийн өмнө хүлээсэн

хариуцлагаа сэтгүүлч аль болохээр хэлбэрлэлтгүй баримтлахад чиглэгдсэн байдаг.

Сүүлийн жилүүдэд манай сэтгүүлчид тэр бүр үнэний дуу хоолой болж чадахгүй байгаа нь үнэн юм. Баримтгүй, дам сургаар нийтлэл бичсэн, бичсэн зүйлээ баримтжуулж чадахгүй байгаагийн улмаас шүүхэд дуудагдсан, хариуцлагад татагдсан, ял зэмлэл сонссон тохиолдол цөөнгүй. Ер нь нэг сэтгүүлчийн алдаа нийт сэтгүүлчдэд нялзаагддаг. Тийм ч учир олон нийтийн дунд эл мэргэжлийн нэр хүнд унасаар байна.

Саяхан МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхмээс явуулсан социологийн судалгааны дүнгийн зарим үзүүлэлт сонирхол татаж буй юм. Судалгаанд хамрагдагсдын дөнгөж 10.1 хувь нь манай сэтгүүлчдийн ёс зүйн баримтлал, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлага сайн төвшинд байна гэж үзсэн бол 8.6 хувь нь энэ асуултанд хариулж мэдэхгүй байна гэжээ. Харин үлдсэн 81.3 хувь нь сэтгүүлчдийн эсрэг саналаа өгсөн байна. Энэхүү 81.3 хувийг задалбал 45.7 хувь нь дунд, 29 хувь нь муу, харин 6.6 хувь нь маш муу⁴ гэж хариулсан нь нэгийг бодогдуулмаар. Чухамдаа сэтгүүлчид бид л өөрсдийгөө «дөрөв дэх засаглал», «хоточ нохой» гэж өргөмжилж байгаагаас биш, олон нийт сэтгүүлчдийг огт өөрөөр үнэлэх болсныг бодолцох цаг нэгэнт болжээ.

Өнөөдөр манай нийгэмд сэтгүүлч сэтгүүлчээ шүүмжлэх ёсгүй гэсэн бичигдээгүй хууль үйлчилж байна. Энэ бол ёс зүйгүй найзыгаа өмгөөлөхдөө гаргаж ирсэн «хууль». Энэ бол өөрийгөө хаацайлахын тулд ёс зүйгүй сэтгүүлчдийн

уухайлан шүүрч авсан «хууль». Ингэснээр ёс зүйгүй нэгнээ шүүмжилсэн, нөхөр ёсны зөвлөгөө өгсөн сэтгүүлч рүү дайрдаг, «барьж иддэг» тогтолцоо бүрдчихээд байгаа нь нууц биш юм. Яг үнэндээ сэтгүүлчийн гаргасан мэргэжлийн алдааг оношилдог арга, хэмждэг хэмжүүр манайд илт дутагдаж байна. Тэгвэл тухайн сэтгүүлч мэргэжлийн алдаа гаргасан эсэхийг оношилдог ганц багаж бол сэтгүүлчийн ёс зүйн зарчим юм.

Сэтгүүлчийн ёс зүйн зарчим бол дарга дээрээс тулгадаг, эсвэл эрдэмтэн өрөөндөө сууж байгаад боловсруулчихдаг шаардлагуудын хэлхээ биш. Сэтгүүлчийн ёс зүйн зарчим бол тогоонд нь чанагдсан сэтгүүлчид өөрсдийн туршлага дээр тулгуурлан боловсруулдаг мэргэжлийн үйл ажиллагааны мөрдлөг юм. Манай чөлөөт сэтгүүл зүйн хөгжлийн өнөөгийн байдал Монголын сэтгүүлчдийг ёс зүйн зарчимтай болохыг шаардаж байна.

Ишлэл

1. Мкртчян А.А. 1995. Пособие по курсу «История журналистики США XVIII-XIX вв.». М. Изд-во Росс. Ун-та дружбы народов. С. 28.
2. Авраамов Д.С. 1999. Профессиональная этика журналиста. М. С. 50-51.
3. Bruun L. 1979. Professional Codes in Journalism. P. 26-30.
4. Олон нийтийн санал бодол, чөлөөт хэвлэлийн төлөвшил. 2003. УБ. 18 дахь тал.

Ашиласан бүтээлийн жагсаалт

1. Авраамов Д.С. 1999. Профессиональная этика журналиста. М.
2. Лазутина В.Г. 2000. Профессиональная этика журналиста. М.
4. Шостак М.И. 2002. Репортёр: профессионализм и этика. М.
5. Christians N., Clifford J., others. 1992. Media Ethics. Longman.
6. Day L. A. 1994. Ethics in Media Communications Cases and Controversies. Wadsworth Publishing com.

Actual Problems of Ethics of Journalists

The urgent questions of today's journalists are professional ethics and the responsibility which accept in the society. People consider that level of professional ethics of journalists is fallen down. From the statistic research, only 10,1 percent consider that the level of professional ethics of journalists is good, while 8,6 per didn't know how to answer. But 81,3 percent denied the journalists.

Author analized that today it's the time that journalists must improve their professional ethics.